



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХӨХҮҮЛЭН ДЭМЖИХ, ХАМГААЛАХ
ТУХАЙ МОНГОЛ УЛС, МАЛАЙЗ УЛСЫН ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улс, Малайз Улс \цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд"
гэх\

эдийн засаг, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг урт
хугацааны үндсэн дээр өргөтгөн бэхжүүлэх, ялангуяа Хэлэлцэн
тохирогч нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө
Талын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулах таатай нөхцөл бүрдүүлэхийг
эрнэлзэн,

Хэлэлцэн тохирогч хоёр Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө
оруулалтыг хамгаалах болон Хэлэлцэн тохирогч хоёр Талын эдийн
засгийг хөгжүүлэхэд тус дөхөм болох үүднээс хөрөнгө оруулалт,
ажил хэрэгч санаачлагыг урамшуулах шаардлагатайг хүлээн
зөвшөөрч,

дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Нэр томъёо

1. Энэхүү хэлэлцээрт:

а\ "Хөрөнгө оруулалт" гэж аливаа төрлийн эд хөрөнгө,
тухайлбал дор дурдсан эд хөрөнгийг хэлэх боловч зөвхөн
эдгээрээр үл хязгаарлагдана. Үүнд:

I. хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн үл хөдлөх
хөрөнгийн барьцаа, эд хөрөнгө саатуулан барих эрх, барьцаа,

II. компанийн ногдол хувь, хувьцаа, облигаци буюу компанид
оруулсан эд хөрөнгө,

III. мөнгөн төлбөрийг эсхүл санхүүгийн үнэлгээ бүхий аливаа
үүргийн биелэлтийг шаардах эрх,

IV. оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх, түүний дотор
зохиогчийн эрх, патент, барааны тэмдэг, пүүсийн нэр, үйлдвэрийн
дизайн, худалдааны нууц, техникийн ажилбар, ноу-хау, бизнесийн
нэр хүнд,



V.хууль эсхүл гэрээгээр олгосон аливаа эрх түүний дотор байгалийн баялгийг эрх хайх, олборлох, боловсруулах, ашиглах концесс,

б\“Орлого” гэж хөрөнгө оруулалтын үр дүнд олсон орлого, тухайлбал ашиг, хүү, хөрөнгийн өсөлтийн ашиг, ногдол хувь, хувьцаа, ногдол ашиг, роялти, төлбөрт үйлчилгээний хөлсийг хэлэх бөгөөд зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.

в\“Хөрөнгө оруулагч” гэж:

I.Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хууль тогтоомжийнх нь дагуу түүний харьяат бөгөөд нутаг дэвсгэрт нь байнга оршин суугаа аливаа хувь хүн, эсхүл

II.Хэлэлцэн тохирогч тухайн Талын хууль тогтоомжийнх нь дагуу зохих ёсоор байгуулагдаж бүртгэгдсэн аливаа корпораци, холбоо, компани, хамтарсан үйлдвэр, байгууллага, нийгэмлэгийг тус тус хэлнэ.

г\“Нутаг дэвсгэр” гэж:

I.Монгол Улсын хувьд Монгол Улсын бүрэн эрх буюу хууль үйлчлэх нутаг дэвсгэрийг хэлнэ.

II.Малайз Улсын хувьд Малайзын Холбооны Улсын хуурай бүх нутаг дэвсгэр, нутаг дэвсгэрт нь багтах далай, түүний ёроол, агаар мандлыг хэлнэ.

д\“Чөлөөтэй хэрэглэж болох валют” гэж АНУ-ын доллар, фунт стерлинг, германы марк, францын франк, японы иен эсхүл олон улсын худалдааны төлбөрт болон олон улсын валютын гол зах зээлийн гүйлгээнд түгээмэл хэрэглэдэг бусад аливаа валютыг хэлнэ.

2.I. 1 дэх хэсгийн“а”-д дурдсан “Хөрөнгө оруулалт” гэсэн нэр томъёо нь зөвхөн Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомж, үндэсний бодлогын дагуу оруулсан бүх хөрөнгө оруулалтад хамаарна.

II.Оруулсан эд хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх нь түүний хөрөнгө оруулалтын мөн чанарыг үл хөндөнө.Гэхдээ анх хөрөнгө оруулахад зөвшөөрөл авч байсан бол эд хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх нь уг зөвшөөрөлд харшлах ёсгүй.



Хоёрдугаар зүйл

Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, хамгаалах

1.Хэлэлцэн тохирогч Тал тус бүр өөрийн хууль тогтоомж,үндэсний бодлогын дагуу өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалт хийх явдлыг хөхүүлэн дэмжиж, таатай нөхцөл бүрдүүлэх бөгөөд уг хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрнө.

2.Хэлэлцэн тохирогч аль ч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад ямагт шударга, эрх тэгшээр хандаж, түүнийг өөрийн нутаг дэвсгэрт бүрэн хамгаалж, аюулгүй байдлыг нь хангана.

Гуравдугаар зүйл

Нэн тааламжтай үндэстний нөхцөл

1.Хэлэлцэн тохирогч Тал тус бүр өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад олгодоогоос дутуугүй таатай нөхцөл олгож, хөрөнгө оруулалтад шударга, эрх тэгшээр хандана.

2.Хэлэлцэн тохирогч Тал тус бүр өөрийн нутаг дэвсгэрт Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад өөрийн хөрөнгө оруулалтаа удирдан захирах,хэвийн ажиллагаатай байлгах, ашиглах, эзэмших, захиран зарцуулахад нь гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагчдад олгодоогоос дутуугүй таатай нөхцөл олгож, тэдэнд шударга, эрх тэгшээр хандана.

3.Хэлэлцэн тохирогч нэг Тал дор дурдсан нөхцөл байдлын улмаас өөр улсын хөрөнгө оруулагчдад олгож болох аливаа нөхцөл, хөнгөлөлт, давуутай эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад нэгэн адил олгох үүрэгтэй мэтээр гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагчдад олгодоогоос дутуугүй таатай нөхцөл олгох тухай энэхүү Хэлэлцээрийн заалтыг тайлбарлахгүй байвал зохино:

а\Хэлэлцэн тохирогч аль нэг Тал гишүүн нь байгаа эсхүл цаашид гишүүн нь болж болох үйл ажиллагаагаа явуулж буй буюу ирээдүйд явуулах гаалийн аливаа холбоо, эсхүл худалдааны чөлөөт



бүс, нийтийн зах зээл, валютын холбоо, эсхүл тэдгээртэй адилтгаж болох олон улсын гэрээ хэлэлцээр, бүсийн хамтын ажиллагааны бусад хэлбэрийн улмаас,

б\Бүхэлдээ эсхүл гол төлөв татварын асуудал зохицуулж буй олон улсын гэрээ хэлэлцээр, тохиролцоо эсхүл дотоодын хууль тогтоомжийн улмаас.

Дөрөвдүгээр зүйл

Хохирлыг нөхөн төлөх

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэрт дайн, эсхүл зэвсэгт мөргөлдөөн, хувьсгал, үндэсний онц байдал, бослого, үймээн самуун, эмх замбараагүй байдал гарсны улмаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчдад хохирол учирсан байвал эд хөрөнгийг буцаан олгох, хохирлыг нөхөн төлөх, эсхүл хохирлыг өөр аргаар зохицуулан шийдвэрлэх асуудлын хувьд Хэлэлцэн тохирогч тухайн Тал нь гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

Тавдугаар зүйл

Эд хөрөнгийг хураан авах

1. Дор дурдсанаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч аль ч Тал Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хураан авах, нийгэмчлэх аливаа арга хэмжээ авч болохгүй.

а\хуулийн дагуу эсхүл нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор арга хэмжээ авах,

б\ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр арга хэмжээ авах,

в\хохирлыг нэн даруй, бүрэн хэмжээгээр, үр ашигтайгаар нөхөн төлөх. Ийм нөхөн төлбөрийн хэмжээ нь эд хөрөнгийг хураан авах гэж байгаа тухай мэдээ нийтийн хүртээл болохоос өмнөхөн үеийн дэлхийн зах зээлийн үнэлгээтэй дүйцсэн байвал зохих бөгөөд төлбөрийг чөлөөтэй хэрэглэж болох валютаар Хэлэлцэн тохирогч тухайн Талаас саадгүй гүйцэтгэнэ. Нөхөн төлбөрийг аливаа зүй бус шалтгаанаар саатуулсан тохиолдолд хэрэв хуулиар ханшийг тогтоогоогүй бол хоёр талын тохиролцсон ёсоор нөрдөж буй арилжааны ханшийг үндэслэн хүүг нэмэн тооцно.



2.Эрх ашиг нь хөндөгдсөн хөрөнгө оруулагч хөрөнгийг нь хураан авсан Хэлэлцэн тохирогч Талын шүүхийн эсхүл хөндлөнгийн байгууллагаар өөрийн хэргийг болон хөрөнгө оруулалтынхаа үнэлгээг энэ зүйлд заасан зарчмын дагуу нэн даруй хянуулах эрхтэй.

Зургадугаар зүйл

Төлбөрийг шилжүүлэх

1.Хэлэлцэн тохирогч Тал тус бүр өөрийн хууль тогтоомж, үндэсний бодлогын дагуу дараахь төлбөрийг зүй бус сааталгүйгээр, чөлөөтэй хэрэглэж болох валютаар гүйцэтгэхийг зөвшөөрнө:

а\нийт ашиг, ногдол ашиг, роялти, техникийн тусламж, төлбөрт үйлчилгээний хөлс, хүү, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтаас олсон гүйлгээний бусад орлого,

б\Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн аливаа хөрөнгө оруулалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн татан буулгаснаас олсон орлого,

в\ Хэлэлцэн тохирогч хоёр Тал хөрөнгө оруулалт гэж хүлээн зөвшөөрсөн Хэлэлцэн тохирогч нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчид төлөх зээлийн төлбөрийн сан,

г\Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулсантай холбогдуулан Хэлэлцэн тохирогч нэг Талаас тэнд ажиллаж байгаа хөрөнгө оруулагчийн нийт цалин болон бусад нөхөн төлбөр.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шилжүүлгийн хувьд баримтлах ханш гэж шилжүүлгийг хийх тэр өдрийн ханшийг хэлнэ.

3.Хэлэлцэн тохирогч Талууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шилжүүлгийг хийхэд гуравдагч аливаа улсын хөрөнгө оруулагчаас шилжүүлэг хийхэд нь олгогдоос дутуугүй таатай нөхцөл олгох үүрэг хүлээнэ.



Долдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Тал, Хэлэлцэн тохирогч
нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хоорондын
хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх

1.Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нь Хэлэлцэн тохирогч нэг Тал, Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хооронд дор дурдсан асуудалтай холбогдон гарсан аливаа маргааныг 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Вашингтон хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон "Улс болон нөгөө улсын иргэдийн хоорондын хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц"-ийн дагуу байгуулагдсан хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төв цаашид "Төв" гэх\-д шийдвэрлүүлэхээр шилжүүлж байхаар тохиров.

I.Хэлэлцэн тохирогч тухайн нэг Талаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулалтын талаар хүлээсэн үүрэгтэй холбогдсон маргаан,

II.Хөрөнгө оруулалтын талаар энэхүү Хэлэлцээрт заасан буюу эсхүл Хэлэлцээрээр хүлээсэн эрхээ хөрөнгө оруулагч илт зөрчсөнтэй холбогдсон маргаан.

2.Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу байгуулагдаж, бүртгэгдсэн компанийн хувьд маргаан гарахаас өмнө хувьцааных нь дийлэнхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хөрөнгө оруулагч эзэмшиж байсан бол Конвенцийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "6" заалтын дагуу уг компанийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын компани хэмээн үзэж Конвенцийн заалтыг хэрэглэнэ.

3.I Хэлэлцэн тохирогч Тал болон хөрөнгө оруулагч нь 1 дэх хэсэгт дурдсан аливаа маргааныг зөвлөлдөх, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэхийг зорино.Хэрэв маргааныг дээрх арга замаар 3 сарын дотор шийдвэрлэж чадахгүй бол маргааныг эвлэрүүлэх аргаар эсхүл шүүхээр шийдвэрлүүлэхээр Конвенцийн дагуу байгуулагдсан Төвд шилжүүлнэ.Гэхдээ маргаанд оролцогч хөрөнгө оруулагч ийнхүү маргааныг Төвд шилжүүлэхийг зөвшөөрч буйгаа бичгээр мэдэгдэх ёстой.Маргаанд оролцогч ал ч Тал Конвенцийн 28, 36 дугаар зүйлд заасан ёсоор шүүх ажиллагааны талаарх хүсэлтээ Төвийн ерөнхий нарийн бичгийн даргад хандан тавьж болно.Харин маргаанд оролцогч хөрөнгө оруулагч нь маргааныг маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Талын шүүх, засаг захиргааны шүүх эсхүл эрх бүхий хуулийн бусад байгууллагад шилжүүлж болохгүй.



II.Маргааныг эвлэрүүлэх аргаар эсхүл шүүхээр шийдвэрлүүлэх эсэх талаар санал зөрөх тохиолдолд маргаанд оролцогч хөрөнгө оруулагчийн санал шийдвэрлэгч байна.Маргаанд оролцогч Хэлэлцэн тохирогч Тал маргааныг шүүн таслах ажиллагааны аль ч үе шатанд ямар нэгэн эсэргүүцэл илэрхийлээгүй буюу өөрийгөө зөвтгөөгүй эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлж буй тохиолдолд маргаанд оролцогч хөрөнгө оруулагч нь даатгалын гэрээний дагуу хохирлын төлбөрөө бүхэлд нь эсхүл хэсгийг нь авч эхэлнэ.

4.Дор дурдсан нөхцөлд Хэлэлцэн тохирогч Тал тус бүр аливаа маргааныг дипломат шугамаар зохицуулна.

I.Төвийн ерөнхий нарийн бичгийн дарга, эсхүл Төвөөс байгуулсан эвлэрүүлэх комисс буюу шүүх тухайн маргааныг Төвийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй гэж шийдвэрлэвэл,

II.Хэлэлцэн тохирогч нөгөө Тал шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй буюу эсхүл шийдвэрийн талаар гомдолтой бол.

Наймдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх

1.Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах буюу хэрэглэх талаар Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд гарсан маргааныг аль болох дипломат шугамаар шийдвэрлэж байна.

2.Хэрэв Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд гарсан маргааныг дээрх арга замаар шийдвэрлэж чадаагүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Талын хүсэлтээр маргааныг арбитрын шүүхэд шилжүүлнэ.

3.Арбитрын шүүхийг маргаан тус бүрээр дор дурдсан журмаар байгуулна.Маргааныг арбитражийн журмаар шийдвэрлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш хоёр сарын дотор Хэлэлцэн тохирогч Тал тус бүр шүүхийн нэг нэг гишүүнийг тус бүр томилно.Эдгээр хоёр гишүүн нь аль нэг гуравдагч орны иргэнийг сонгон авч түүнийг Хэлэлцэн тохирогч хоёр Талын зөвшөөрснөөр шүүхийн даргаар томилно.Даргыг шүүхийн бусад хоёр гишүүн томилогдсоноос хойш хоёр сарын дотор томилно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан хугацааны дотор зохих хүмүүсийг томилж чадаагүй бол, хэрэв өөр тохиролцоо байхгүй бол Хэлэлцэн тохирогч аль нэг Тал тэдгээрийг томилуулахаар Олон улсын шүүхийн даргад хүсэлт гаргаж болно. Хэрэв тэрээр



Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн байх эсхүл дээр дурдсан үүргийг аливаа бусад шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй бол зохих хүмүүсийг томилуулахаар Олон улсын шүүхийн дэд даргыг урина. Хэрэв Дэд дарга нь мөн Хэлэлцэн тохирогч аль нэг Талын иргэн байх эсхүл дурдсан үүргийг гүйцэтгэх боломжгүй бол Олон улсын шүүхийн удаах албан тушаалтныг зохих хүмүүсийг томилуулахаар урих бөгөөд тэр нь Хэлэлцэн тохирогч аль ч Талын иргэн биш байвал зохино.

5. Арбитрын шүүх нь шийдвэрээ олонхийн саналаар гаргана. Ийм шийдвэрийг Хэлэлцэн тохирогч Талууд заавал биелүүлэх ёстой. Хэлэлцэн тохирогч Тал тус бүр нь өөрийн арбитрч болон арбитрын хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийгөө төлөөлүүлсний зардлыг хариуцна. Шүүхийн даргын болон бусад зардлыг Хэлэлцэн тохирогч Талууд тэнцүү хэмжээгээр хариуцна. Гэхдээ шүүх Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нэгэнд илүү зардал хариуцуулах тухай шийдвэр гаргаж болох бөгөөд Хэлэлцэн тохирогч хоёр Тал уг шийдвэрийг заавал биелүүлэх ёстой. Хэрэг хянан шийдвэрлэх журмыг шүүх өөрөө тогтооно.

Есдүгээр зүйл

Эрх, үүрэг шилжих

1. Хэлэлцэн тохирогч Тал эсхүл түүний томилсон төлөөний байгууллага нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дэх хөрөнгө оруулалтын хувьд олгосон өөрсдийн баталгааныхаа дагуу өөрийн хөрөнгө оруулагчиддаа төлбөр хийх нөхцөлд, нутаг дэвсгэрт нь хөрөнгө оруулалт хийгдсэн Хэлэлцэн тохирогч Тал:

а) хөрөнгө оруулагч нь өөрийн аливаа эрх эсхүл гомдлын шаардлага, нэхэмжлэл гаргах эрхээ өөрийн улсын хууль тогтоомж эсхүл өөрийн улсад хийгдсэн хууль зүйн хэлцлийн дагуу өөрийн улсын Хэлэлцэн тохирогч Тал эсхүл түүний томилсон төлөөний байгууллагад шилжүүлснийг түүнчлэн,

б) эрх, үүрэг ийнхүү шилжсэний дагуу хөрөнгө оруулагчийн Хэлэлцэн тохирогч Тал эсхүл түүний томилсон төлөөний байгууллага тухайн хөрөнгө оруулагчийн эрхийг хэрэгжүүлж, гомдлын шаардлага, нэхэмжлэлийг хангуулах эрхтэй болохын зэрэгцээ хөрөнгө оруулалттай холбогдсон үүргийг нь хүлээх болсныг тус тус хүлээн зөвшөөрнө.

2. Шилжсэн эрх буюу гомдлын шаардлага, нэхэмжлэл нь хөрөнгө оруулагчийн өөрийнх нь эрх буюу гомдлын шаардлага, нэхэмжлэлийн үнийн дүнгээс хэтрэхгүй байна.



Аравдугаар зүйл

Хөрөнгө оруулалтын хувьд Хэлэлцээрийг хэрэглэх

Энэхүү Хэлэлцээр нь түүний хүчин төгөлдөр болохоос өмнө буюу хойно Хэлэлцэн тохирогч нэг Талын хөрөнгө оруулагчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт тухайн Талын хууль тогтоомж, үндэсний бодлогын дагуу оруулсан хөрөнгө оруулалтын хувьд мөрдөгдөнө. Гэхдээ энэхүү Хэлэлцээрийн заалтууд нь уг Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан аливаа маргаан буюу нэхэмжлэлд хамаарахгүй.

Арван нэгдүгээр зүйл

Нэмэлт өөрчлөлт

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хэдийд ч Хэлэлцэн тохирогч хоёр Талын тохиролцсоноор түүнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Энэхүү Хэлэлцээрт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт, засвар нь ийм нэмэлт өөрчлөлт, засвар оруулахаас өмнө Хэлэлцээрийн дагуу хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй бөгөөд тэдгээр эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд саад болохгүй.

Арван хоёрдугаар зүйл

Хэлэлцээр хүчин төгөлдөр болох, хүчинтэй байх хугацаа, Хэлэлцээрийг цуцлах

1. Хэлэлцэн тохирогч Талуудын Засгийн газар энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох талаар өөрийн үндсэн хуулийн шаардлагыг ханган биелүүлсэн тухайгаа харилцан мэдэгдэнэ. Энэхүү Хэлэлцээр нь хоёр дахь мэдэгдлийг илгээсэн тэр өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээр нь арван жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу түүнийг цуцлаагүй бол цаашид ч хүчин төгөлдөр хэвээр байна.

3. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрийг цуцлах тухайгаа Хэлэлцээр хүчин төгөлдөр байх анхны 10 жилийн хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл түүнээс хойш хэдийд ч нэг жилийн өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа бичгээр мэдэгдэх замаар энэхүү Хэлэлцээрийг цуцалж болно.



4. Энэхүү Хэлэлцээрийн бүх заалт түүнийг цуцлахаас өмнө оруулсан хөрөнгө оруулалтын хувьд уг Хэлэлцээрийг цуцалсан өдрөөс хойш арван жилийн хугацаанд үргэлжлэн мөрдөгдөнө.

Дээр дурдсаныг нотлон тус тусын Засгийн газраас эрх олгогдсон дор дурдсан төлөөлөгчид энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг *Хуада Луштур* хотноо 1995 оны 7 дугаар сарын "27"-ны өдөр монгол, бахаса малайз, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад ямар нэгэн зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

МАЛАЙЗ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ